



Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний зохицуулалт, үр дүн



Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга Ж.Батсуурь

2018.10.10

Агуулга

01

Зохицуулах зөвлөлийн 2018 оны эхний хагас жилд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

02

Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний зохицуулалт, үнэ тарифын зохицуулалт

03

Тулгамдаж буй асуудлууд, цаашдын зорилт



Зохицуулах зөвлөлөөс 2018 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа



Зохицуулах зөвлөлөөс 2018 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар

Зөвлөлийн үйл ажиллагаа:

Эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэл 94.4%, 316,2 сая.төг, орлогын гүйцэтгэл 82,1% буюу 280,9 сая.төг –ийн зохицуулалт үйлчилгээний хөлсийг төвлөрүүлсэн байна.

Зөвлөлийн ажлын алба өнгөрсөн 6 сард шинэ байранд нүүж орон, тохижсон. БХБЯ-ны удирдлагууд, Сайд, дэд сайд, ТНБД, газрын дарга нар, мөн Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын бүрэлдэхүүн ирж, Зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж, уулзалт хийсэн.

Зохицуулах зөвлөлийн ажлын алба 2018 оны эхний хагас жилд нийт **56 ТОГТООЛЫН** төслийг батлуулав. Үүнд:

- Тусгай зөвшөөрөл сунгуулсан 23, шинээр олгосон 6, хүчингүй болгосон 1 тогтоол баталсан.

- Тарифын санал ирүүлсэн 19 байгууллагын материалыг хянаж, бөөний тариф болон хэрэглэгчдийн тарифт өөрчлөлт оруулсан. Тухайлбал: Улаанбаатар хот болон Дорноговь аймгийн хэрэглэгчдийн цэвэр бохир усны үйлчилгээний тарифыг шинэчлэн баталж мөрдүүлсэн.



Зохицуулах зөвлөлөөс 2018 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар

Зөвлөлийн үйл ажиллагаа:

Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах чиглэлээр:

Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2018 оны эхний хагас жилийн турш орон нутагт **8**, УБ хотын хэмжээнд **7** удаагийн хяналт, шалгалтын ажлыг тус тус хийж гүйцэтгэв.

Хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр

Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэг БХБЯ дээр байгуулагдан, тэнд Зөвлөлийн ажлын албанаас төлөөлөл ажиллаж байна.

Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах ажлын хэсэгт Зөвлөлийн төлөөллүүд орсон байгаа.



Зохицуулах зөвлөлөөс 2018 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар

Зөвлөлийн үйл ажиллагаа:

Хамтын ажиллагааны чиглэлээр

Гадаад хамтын ажиллагааны чиглэлээр бид НҮБ-ийн Хүүхдийн сантай нягт хамтран ажиллаж байна. Мөн түүнчлэн Азийн усны холбоо-ны удирдах зөвлөлийн 6-р хуралд оролцож, 2020 онд зохиогдох Азийн усны 7 хоногийг Индонезид зохион байгуулах комиссд орж ажиллахаар болсон.

Мэргэжлийн боловсон хүчнийг чадавхижуулах, салбарын үйл ажиллагааг сайжруулах, гадаад дотоод хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэх чиглэлээр “МНААХолбоо”ТББ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.

Эрчим хүчний зохицуулах хорооны удирлагатай НАА-н салбарт тулгамдаад байгаа асуудлын талаар уулзалт зохион байгуулж, Салбар дундын зохицуулалт, санхүүгийн өр авлага барагдуулах, туршлага солилцох талаар 2 зохицуулах байгууллага цаашид үр ашигтай хамтран ажиллахаар болсон.



Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний салбарын зохицуулалт



Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний салбарын зохицуулалт



Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний мөн чанар нь **МОНОПОЛЬ** шинжтэй учир өрсөлдөөний гол шалгуур болох **үйлчилгээний үнэ,** чанарын асуудлаар зохицуулалт хийх шаардлагатай болдог.



Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний салбарын зохицуулалт

Монополь байдал нь эдгээр 4 хүчин зүйлээс хамаарна.

- Нийгмийн зорилт нь үйлчилгээний чанар, хүртээмжээс,
- Хэрэглэгчдийн эрх ашиг нь өргөдөл, гомдлоос,
- Байгаль орчны хүчин зүйл нь байгальд нийлүүлж буй хаягдал усны цэвэрлэгээний түвшингээс,
- Аюулгүй байдал нь ундны усны чанараас,





Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний салбарын зохицуулалт

Нийгмийн зорилт нь үйлчилгээний чанар, хүртээмжээр:



Хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлэх харилцааны стандартад үйлчилгээний ажилтнуудыг суралцуулах, үүнд чиглэсэн сургалтуудад хамруулах.



Мэргэжилтэй ажилтнуудыг мэргэшүүлэх.

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг сайжруулах.



Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний салбарын зохицуулалт

Байгаль орчны хүчин зүйл нь байгальд нийлүүлж буй хаягдал усны цэвэрлэгээний түвшингээс:

Цэвэрлэх байгууламжийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөр



Улсын хэмжээнд 130 гаруй бохир ус цэвэрлэх байгууламж байна. Үүнээс хэвийн ажиллагаатай 51, хагас ажиллагаатай 27, огт ажиллагаагүй 47 байна.



Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний салбарын зохицуулалт

Байгаль орчны хүчин зүйл нь байгальд нийлүүлж буй хаягдал усны цэвэрлэгээний түвшингээс:



Төвлөрсөн ариутгах татуургын системд холбогдоогүй, эсвэл насос станцаар дамжуулан бохир усыг татан зайлуулдаг, бохир усны цооног бүхий хотхон, хороолол ихсэж байна.



Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний салбарын зохицуулалт

Аюулгүй байдал нь ундны усны чанараас:

"ASTRA VILLA" ХОТХОНД




Төвлөрсөн ус хангамжийн системд холбогдоогүй, бие даасан усны эх үүсвэртэй хотхон, хороолол ихээр баригдсан. Эдгээр хотхоны оршин суугчдын баталгаат ундны усаар хангагдах эрх зөрчигдөх тохиолдол ихсэж байна.





Хуулийн 9.1, 10.1.5, 22.2 дахь заалтуудын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд:


Хүлээн авсан өргөдөл, гомдлын судалгаа
/6 жилээр/




2018.10.01-ний байдлаар 83 өргөдөл, гомдол бүртгэгдсэнээс 37 гомдлыг нь утсаар, үлдсэн 46 өргөдөл, гомдлыг албан бичгээр хүлээн авч, барагдуулсан байна.

БИЧГЭЭР ИРСЭН ӨРГӨДӨЛ

- Төлбөр тооцоо
- Засвар үйлчилгээ
- СӨХ-ны үйл ажиллагаа
- Ус хангамжийг хязгаарласан



УТСААР ИРСЭН ГОМДОЛ:





Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн жагсаалт:

№	Нэхэмжлэгч иргэн, хуулийн этгээдийн нэр	Маргааны төрөл	Шүүхэд хандсан хугацаа	Шүүхээр шийдвэрлэсэн хугацаа	Шийдвэрийн агуулга	Тодруулга
1.	"Цемент шохой" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг	Цэвэр, бохир усны үнэ тариф	2015.03.24	2015.10.06	Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон	Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн
2.	"Зүмбэр орд өргөө" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг	Тусгай зөвшөөрөл олгохыг даалгах, үнэ тариф хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох	2016.05.24	2016.10.07	Эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон	Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн
3.	"Зүмбэр орд өргөө" ХХК-ийн нэхэмжлэлтэй УСУГ-т холбогдох иргэний хэрэгт Зохицуулах зөвлөл хамтран хариуцагчаар татагдсан	Цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр төлөх эсэхтэй холбоотой	2017.02.02	2018.10.03	Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон	Анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн


4.	"Лхатоном сервис" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг	Тусгай зөвшөөрөл олгохыг даалгах	2017.03.02	2017.05.15	Нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч хүлээн зөвшөөрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон	Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн
5.	"Шинэ байр" СӨХ-ны нэхэмжлэлтэй захиргааны хэрэг	"Алтан билэг" ХХК-ийн УХАТ-ын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах	2017.08.04	2017.12.15	Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.	Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн
6.	Сонгинохайрхан дүүргийн 6-р хорооны оршин суугч Б.Нандин-Эрдэнэ нарын нэр бүхий 5 иргэний нэхэмжлэлтэй захиргааны хэрэг	"Баатар дулаан хан" ХХК-ийн УХАТ-ын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах	2017.09.07	2018.03.06	Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон	Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн
7.	"Харуул Алтай" СӨХ болон иргэн М.Баярсайханы нэхэмжлэлтэй захиргааны хэрэг	"Сод эгшиг" ХХК-ийн УХАТ-ын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах	2017.12.05	2018.06.07	Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.	Анхан, давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн

№	Нэхэмжлэгч иргэн, хуулийн этгээдийн нэр	Маргааны төрөл	Шүүхэд хандсан хугацаа	Шүүхээр шийдвэрлэсэн хугацаа	Шийдвэрийн агуулга	Тодруулга
8.	"Баатар дулаан хан" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг	Байрны бүртгэл хүчингүй болгуулах	2017.12.15	2018.10.08	Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.	Анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн
9.	"Тулга констракшн" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг	Цэвэр, бохир усны үнэ тариф хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох	2018.05.22	2018.10.03	Хэргийг хэрэгсэхгүй болгосон	Анхан, давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн



Үнэ тарифын зохицуулалт

Салбарын хөрөнгө, эх үүсвэр түүнд эзлэх авлага, өр төлбөрийн хэмжээ






ТЗЭ-дийн орлого, зардал, ашиг, алдагдал


сая.төг-р

Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	Өөрчлөлт хувь 2016-2017 %
Нийт орлого	115,676.3	165,117.1	230,462.9	248,313.4	271,995.2	287,757.6	6%
УХАТ орлого	70,381.6	89,416.1	99,421.6	125,395.1	133,378.5	144,684.9	9%
Нийт зардал	132,133.2	191,935.8	234,654.0	284,374.6	302,657.5	313,360.6	4%
УХАТ зардал	81,221.1	103,646.3	116,220.7	135,547.3	150,332.2	164,153.2	10%
Нийт алдагдал	-16,456.9	-26,818.7	-4,191.1	-36,061.2	-30,662.2	-24,714.6	-14%
УХАТ алдагдал	-10,839.5	-14,230.2	-16,799.1	-10,152.2	-16,953.7	-19,468.2	25%

Нийт үйл ажиллагаа



УХАТ-ын үйл ажиллагаа





Тулгамдаж байгаа асуудлууд

- Салбарын хуулийн шинэчлэлт удаашралтай байгаа.
- - Ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын бүсийн дэглэмийн хэрэгжилт хангалтгүй байгаа,
- - Салбарын хөрөнгө оруулалт, санхүүгийн зохицуулалтын уялдаа сул
- - Төлбөр бичигдээгүй бохир усанд тавих хяналт хангалтгүй,
- - Бохир усны хяналтын лаборатори хүрэлцээгүй,
- - Салбарын байгууллагуудын урт хугацаат зээлийн асуудал шийдэг- дэхгүй байгаагаас УСУГ болон орон нутгийн НАА-н байгууллагуудын санхүү эдийн засгийн үзүүлэлтүүд доогуур, тарифаар зээлийн асууд-лыг шийдвэрлэх боломжгүй,



Цаашдын зорилт

- - Салбарын эрх зүйн орчныг сайжруулж, хуулийн өөрчлөлтийг цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх талаар БХБЯ-тай хамтран ажиллах,
- - Цэвэр, бохир усны тоолуурын чиглэлээр: Цэвэр, бохир усны тоолуурын лабораторийн хүртээмж, хүчин чадлыг сайжруулахад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах,
- Сум, суурин газрын инженерын байгууламжийн ашиглалт, үйлчилгээг зохицуулалтаар хангах,
- - Усны зүй зохистой хэрэглээг дэмжих, ТЗЭ-дийн зардлыг бууруулах зорилгоор шугам сүлжээний алдагдлыг илрүүлэх, усны бодит алдагдлыг тооцох арга, аргачлалыг боловсронгуй болгож, хэрэгжүүлэх, салбарын инженер техникийн ажилчдад энэ талын мэдлэг мэдээлэл олгох сургалт явуулах, зөвлөмж хүргүүлэх,
- -Үнэ тарифын зохицуулалтаар салбарын хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцлийг бүрдүүлэх



**АНХААРАЛ ТАВЬСАНД
БАЯРЛАЛАА !**